



Хүний нөөцийн сонгон шалгаруулалтын журам

Зорилго

Энэхүү журмын зорилго нь Хавдар судлалын үндэсний төв (цаашид ХСҮТ гэх)-ийн дүрэмд заасан зорилт, зорилгыг хэрэгжүүлэх үүрэг бүхий өндөр мэдлэг, ур чадвартай эрүүл мэндийн ажилтныг сонгон шалгаруулах ажлыг оновчтой зохион байгуулж, төвийн хүний нөөцийг бүрдүүлэхэд оршино.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6.1 дэхь заалтад "эмнэлгийн захирал нь эмнэлгийн дэд захирал болон зохион байгуулалтын нэгжийн удирдлагыг сонгон шалгаруулж, томилох", "Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS6330:2017" стандартын 6.3-д Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт ажиллах эрүүл мэндийн ажилтан нь "Хүний нөөцийг бүрдүүлэхэд тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан нэр дэвшигчийг байгууллагын дотроос болон гаднаас ил тод сонгон шалгаруулж ажилд авна" гэснийг үндэслэж энэхүү журмыг боловсруулсан болно.
- 1.2 Энэхүү журмаар зохицуулагдаагүй харилцааг "Эрүүл мэндийн тухай хууль", "Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль", "Хөдөлмөрийн тухай хууль", "Төрийн албаны тухай хууль", Хавдар судлалын үндэсний төвийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад эрх зүйн актуудыг үндэслэл болгон зохицуулна.
- 1.3 Төвийн батлагдсан орон тоо сул чөлөөтэй болсон, шинээр орон тоо бий болсон үед ажилтан авч ажиллуулах, мөн үндсэн ажилтан хөдөлмөрийн гэрээ дуусгавар болоогүй бөгөөд түүний ажил, албан тушаал Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлд заасны дагуу 3 сараас дээш хугацаагаар хадгалагдсан үед оронд нь хугацаатай гэрээгээр ажилтан авч ажиллуулахад энэ журмыг баримтлан нээлттэй сонгон шалгаруулалтаар хүний нөөцийн бүрдүүлэлтийг хийнэ.

Хоёр. Баримтлах зарчим

- 2.1. **Ажил олгогч** болон түүнийг төлөөлж буй этгээд нь;
 - 2.1.1. Сонгон шалгаруулалтад оролцогчдод нэгэн ижил мэдээлэл өгөх ба эрх тэгш оролцох боломжоор хангана.
 - 2.1.2. Сонгон шалгаруулах үйл явцад хувийн ашиг сонирхлоос ангид ажиллана.
 - 2.1.3. Ёс зүйг чанд баримтлан, шударга, ил тод, тэгш хандах болон нээлттэй, өрсөлдөөний зарчмыг удирдлага болгон бусдын нөлөөлөлд автахгүй энэхүү журмыг мөрдөж ажиллана.
 - 2.1.4. Ажил горилогчдод дарамт шахалт үзүүлэхгүй, байгууллагын талаар сөрөг ойлголт өгөхгүй байх тал дээр анхаарч хүндэтгэлтэй харилцана.
- 2.2. **Ажил горилогч нь:**
 - 2.2.1. Ажил олгогч болон түүнийг төлөөлж буй этгээдэд хууль бусаар нөлөөлж, өөрт давуу байдал бий болгохгүй байна.

- 2.2.2. Ажил олгогч болон түүнийг төлөөлж буй этгээд, бусад өрсөлдөгчдөд хүндэтгэлтэй хандаж, ёс зүйг чанд баримтлана.
- 2.2.3. Хүний нөөцийн бүрдүүлэлтийг гадаад болон дотоод эх үүсвэрээс бүрдүүлэх ба ХСҮТ-ийн дотоод нөөц давуу эрхтэй байна.

Гурав. Сонгон шалгаруулалтад оролцогчдод тавигдах шаардлага

- 3.1. ХСҮТ-д ажиллахыг хүссэн иргэнд тавигдах ерөнхий шаардлага нь захирлын тушаалаар батлагдсан ажлын байрны "Албан тушаалын тодорхойлолт"-д тавигдах шаардлагаар тодорхойлогдоно.
- 3.2. "Албан тушаалын тодорхойлолт"-д заасан шаардлагаас гадна ажил горилогч нь эрүүгийн хэрэгт болон тухайн мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой зөрчлийн хэрэгт холбогдож байгаагүй байх, өмнө нь ажиллаж байсан байгууллагаас сахилгын шийтгэлээр ажлаас чөлөөлөгдөөгүй байх, мөн төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг зөрчиж ёс зүйн алдаа гаргаж байгаагүй байх нэмэлт шаардлага нийт ажлын байранд тавигдана.
- 3.3. Зарим тохиолдолд тухайн мэргэжлийн онцлогоос хамаарч бусад нэмэлт шаардлага тавигдаж болно.

Дөрөв. Сонгон шалгаруулалтын үе шат

4.1. Нэгдүгээр үе шат – Сонгон шалгаруулалт зарлах;

- 4.1.1 ХСҮТ-ийн хүний нөөц, хөгжлийн алба (цаашид "ХНХА" гэх) сул ажлын байрны хэрэгцээг төвийн захиралд танилцуулж, сонгон шалгаруулалт явуулах ажлын байрны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон ХСҮТ-ийн www.cancer-center.gov.mn цахим хуудсаар дамжуулан 14 хүртэлх хоногийн хугацаанд нийтэд зарлана.
- 4.1.2 Зар нь тухайн албан тушаалын ажлын байранд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, бүртгэл хийх хугацаа, байршил, холбоо барих утасны дугаарын мэдээллийг агуулсан байна.
- 4.1.3 Сул ажлын байрны талаар сонирхсон хүмүүст авч ажиллуулах хугацаа, байгуулах хөдөлмөрийн гэрээний төрөл (хугацаатай, туршилтын, контракт г.м) болон сонгон шалгаруулах журмыг танилцуулж болно.

4.2 Хоёрдугаар шат - Баримт бичгийг хүлээн авч, үнэлэх;

Баримт бичиг хүлээн авах;

- 4.2.1 Сонгон шалгаруулалтад орж өрсөлдөх гэж буй иргэдийг 4.1.1-д заасан хугацаанд бүртгэн авна.
- 4.2.2 Сонгон шалгаруулалтад орохоор нэг ажлын байранд 2 ба түүнээс дээш иргэн бичиг баримтыг бүрэн бүрдүүлэн бүртгүүлсэн тохиолдолд шалгаруулалтад оруулна. 3 ба түүнээс дээш зарлаад 1-ээс олонгүй иргэн бүртгүүлсэн тохиолдолд сонгон шалгаруулалтад оруулж болно.
- 4.2.3 Комиссын дарга сонгон шалгаруулалтын товыг тогтоох бөгөөд бүртгэл дууссанаас хойш 10-аас ихгүй хоногт багтаан сонгон шалгаруулна.
- 4.2.4 Сонгон шалгаруулалтад оролцох иргэд дараах бичиг баримтыг бүрдүүлнэ.
 - 4.2.4.1 Төрийн албан хаагчийн анкет (Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор баталсан маягт-1-ийг бүрэн бөглөж, цээж зураг наасан байх);
 - 4.2.4.2 Иргэний үнэмлэхний хуулбар эсхүл төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia)-ээс авсан лавлагаа;